



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 29

Есөнбулаг сум

Аймгийн тооллогын комиссын бүрэлдэхүүнийг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 16, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, Хүн ам, орон сууцны тооллогын улсын комиссын 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогыг зохион байгуулах аймгийн тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:	Аймгийн Засаг дарга
Орлогч дарга:	Статистикийн хэлтсийн дарга
Гишүүд:	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Цэргийн штабын дарга
	Авто тээврийн төвийн дарга
	Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
	Онцгой байдлын газрын дарга
	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
	Цагдаагийн газрын дарга
	Эрүүл мэндийн газрын дарга
	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
	Гаалийн хорооны дарга
	Гадаадын иргэн, харьяатын газрын
	Говь-Алтай аймаг дахь хэлтсийн дарга
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн дарга

Есөнбулаг сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч

Нарийн бичгийн дарга: Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. Хүн ам, орон сууцны тооллогын бэлтгэл ажлыг хангаж, зардлыг орон нутгийн төсөвт тусган, холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг комиссын дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА



Т.ТАНЗОРИГ